

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨРТ АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ЭРХЭЛСЭН АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 18-ний өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь УИХ-ын 2024 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилго, зорилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн хэрэгжүүлэгчээр туссан зорилтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2025 оны **12 дугаар** сарын байдлаар холбогдох газар, хэлтсүүдээс гаргаж нэгтгэн ирүүлсэн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

УИХ-ын 2024 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар үндсэн хэрэгжүүлэгчээр туссан 4 бодлогын хүрээнд 9 зорилго 21 зорилтын 41 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үндсэн хэрэгжүүлэгчээр хяналтад авсан нийт 41 төсөл, арга хэмжээг бусад яам, агентлаг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд гүйцэтгэлийн тайланг **78.02** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

Төсөл, арга хэмжээний биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Бүсийн төрөлжсөн хөгжлийн бодлогын хүрээний 6 зорилтын 10 төсөл, арга хэмжээний биелэлт **47.9** хувь,
- Хүний хөгжлийн бодлогын 1 зорилтын 1 төсөл, арга хэмжээний биелэлт **100.0** хувь,
- Эдийн засгийн бодлогын 14 зорилтын 29 төсөл, арга хэмжээний биелэлт **64.2** хувь,
- Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 1 зорилтын 1 төсөл, арга хэмжээний биелэлтийг **100.0** хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны  
хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэгчээр  
туссан зорилго, зорилт, төсөл, арга хэмжээний  
хэрэгжилтийн үнэлгээний товчоо

Зорилго	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Үнэлгээ /%/				ДУНДАЖ ДҮН /%/
			85-100	70-85	0-70%	Х.Б	
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	6	10	1	2	7	-	47.9
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	1	1	1	-	-	-	100.0
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	14	29	14	-	14	1	64.2
ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	1	1	1	-	-	-	100.0
<b>НИЙТ</b>	<b>22</b>	<b>41</b>	<b>17</b>	<b>2</b>	<b>21</b>	<b>1</b>	<b>78.02</b>

**Дөрөв. Дүгнэлт.**


1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн хэрэгжүүлэгчээр тусгагдсан 41 арга хэмжээний дундаж гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын байдлаар **78.02%-тай**, өссөн дүн **40.93%-тай** дүгнэлээ.
2. Үндсэн хэрэгжүүлэгчээр тусгагдсан нийт 41 төсөл, арга хэмжээнээс 17 төсөл, арга хэмжээ 85-аас дээш буюу бүрэн хангалттай арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтод түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, 2 төсөл, арга хэмжээ 70-85 хүртэл буюу арга хэмжээ шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай, харин 21 арга хэмжээ 70 хүртэл буюу хангалтгүй бөгөөд удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт оновчгүй, төсөв хөрөнгө тусгагдаагүйгээс хэрэгжихэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн.
3. “Үр дүнгүй” буюу “үр дүн хангалтгүй” гүйцэтгэлтэй үнэлэгдсэн төсөл, арга хэмжээ нь санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тайлан ирүүлээгүй, арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагыг буруу тодорхойлсон, нотлох баримт хавсаргаагүй, “арга хэмжээний хэрэгжилтийн хувь” гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд үе шат бүрээр нь оновчтой төлөвлөөгүй, эцсийн хүрэх үр дүнгээр нь тодорхойлсон учир хэрэгжилтийн хувийг бага үнэлэх шалтгаан болсон байна.

**Тав. Санал, зөвлөмж.**

1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх.


2. Зорилтыг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгоог тухай бүр цуглуулж тайланд хавсаргах;
3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд үндсэн хэрэгжүүлэгчээр тусгагдсан зарим төсөл, арга хэмжээ нь "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харьяаны аж ахуйн нэгж компанийн саналаар тусгагдсан боловч хэрэгжилт, үр дүнг дээд шатны байгууллагад тус яам дангаар хариуцан ажиллаж байна. Иймд эдгээр төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын удирдамжаар хангах замаар залруулах, бодлогын түвшний оролцоо, компанийн хэрэгжүүлэх арга хэмжээний зааг ялгааг тодорхой болгож сайжруулах шаардлагатай байна.
4. Мөн тус яамны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээ нь эдийн засгийг тэлэх, экспортын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой ч төсөв, хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалан хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байгаа тул төлөвлөлт болон санхүүжилтийг тодорхой болгож, зорилтот түвшинг хэрэгжихүйц байдлаар тооцоолон холбогдох дээд шатны байгууллагатай зөвшилцөн шийдвэрлүүлэх.

ТАЙЛАН ХЯНАСАН:  
ХШУДАГ-ЫН ДАРГА



Ц.ӨНӨРНАСАН

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:  
ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ



Ц.ТЭМҮҮЖИН